

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**  
**ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.ДЭЛГЭРСАЙХАНЫ**  
**2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлууд дараах хугацаанд хуралдав.**

- 1.1. 2022.01.13-ны өдөр;
- 1.2. 2022.01.24-ний өдөр;
- 1.3. 2022.01.27-ны өдөр;
- 1.4. 2022.02.17-ны өдөр;
- 1.5. 2022.03.03-ны өдөр;
- 1.6. 2022.03.14-ний өдөр;
- 1.7. 2022.03.31-ний өдөр;
- 1.8. 2022.04.07-ны өдөр;
- 1.9. 2022.04.11-ний өдөр;
- 1.10. 2022.04.18-ны өдөр;
- 1.11. 2022.04.19-ний өдөр;
- 1.12. 2022.04.21-ний өдөр;
- 1.13. 2022.04.28-ний өдөр;
- 1.14. 2022.05.29-ний өдөр;
- 1.15. 2022.06.03-ны өдөр;
- 1.16. 2022.06.23-ны өдөр;

**2. Аудитын хорооны хурал дараах хугацаанд хуралдав.**

- 2.1. 2022.02.10-ны өдөр.

**3. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал хуралдсан байдал.**

- 3.1. 2022.01.26-ны өдөр;
- 3.2. 2022.02.11-ний өдөр;
- 3.3. 2022.03.29-ний өдөр;
- 3.4. 2022.04.21-ний өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. ХХБ-аас 2022 онд баримтлах Эрсдэлийн аппетитыг батлах;

2. Банкны хөрөнгө оруулалттай компанийн ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлуудад оролцох, шийдвэр гаргах, холбогдох бичиг баримтанд гарын үсэг зурах эрх олгох;
3. Банкны ажилтнуудын орон тоо, цалингийн зардлыг шинэчлэн батлах;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, гүйцэтгэлтэй танилцах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах;
7. ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах;
8. Банкны тогтворжуулах төлөвлөгөөг батлах;
9. Үнэт цаас гаргах эрх олгох;
10. Банкны 2022 онд баримтлах “Чанаргүй активыг бууруулах стратеги”;
11. ЭУХ-ны 2021 оны товч тайлан зэрэг бусад асуудлууд болно.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэрүүд байсан гэж үзэж байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу тайлант хугацаанд банкны холбогдот этгээдтэй хийх 3 хэлцэлд зөвшөөрөл өгөх тухай шийдвэр гаргалтанд саналаа өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан.


ТУЗ болон түүний дэргэдэх ажлын албанаас МУ-ын хууль, зохицуулагч байгууллагын дүрэм, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн сайжруулах, ДАГ-ын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, зохистой засаглыг хангах хүрээнд ахиц дэвшил гарган ажиллаж байна гэж хувьдаа дүгнэж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрмээр хараат бус гишүүнд олгогдсон эрх, үүргийн хүрээнд ажиллахыг удирдлага болгосон болно.

ХХБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн,

Аудитын хорооны дарга,

Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн



Ж.Дэлгэрсайхан

2022 оны 7-р сарын 15



**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН  
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит, ээлжит бус хурлуудад цахимаар оролцож болон бичгээр холбогдох тогтоолын төсөлд саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал дараах хугацаанд хуралдав.**

- 1.1. 2022.01.13-ны өдөр;
- 1.2. 2022.01.24-ний өдөр;
- 1.3. 2022.01.27-ны өдөр;
- 1.4. 2022.02.17-ны өдөр;
- 1.5. 2022.03.03-ны өдөр;
- 1.6. 2022.03.14-ний өдөр;
- 1.7. 2022.03.24-ний өдөр;
- 1.8. 2022.03.31-ний өдөр;
- 1.9. 2022.04.15-ны өдөр;
- 1.10. 2022.04.18-ны өдөр;
- 1.11. 2022.04.19-ний өдөр;
- 1.12. 2022.04.21-ний өдөр;
- 1.13. 2022.04.28-ний өдөр;
- 1.14. 2022.06.23-ны өдөр;

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. ХХБ-аас 2022 онд баримтлах Эрсдэлийн аппетитыг батлах;
2. Банкны хөрөнгө оруулалттай компанийн ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлуудад оролцох, шийдвэр гаргах, холбогдох бичиг баримтанд гарын үсэг зурах эрх олгох;
3. Банкны ажилтнуудын орон тоо, цалингийн зардлыг шинэчлэн батлах;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, гүйцэтгэлтэй танилцах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах;
7. ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах;
8. Банкны тогтворжуулах төлөвлөгөөг батлах;
9. Үнэт цаас гаргах эрх олгох;
10. Банкны 2022 онд баримтлах “Чанаргүй активыг бууруулах стратеги”;
11. ХХБ-ны 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланг батлах;
12. Ногдол ашиг хуваарилах;

13. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах хэлцлийг зөвшөөрөх зэрэг болно.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлийг авч хэлэлцсэн 2 удаагийн хуралд оролцон саналаа өгсөн.


ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх ажлын албаны зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэх, цар тахлын нөхцөл байдалд зохицон ажиллах тал дээр ахиц дэвшил гарган ажиллаж байна гэж бодож байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг чармайж ирсэн болно.

ХХБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн,

Цалин урамшууллын болон, нэр дэвшүүлэх

хорооны гишүүн



Ж.Болормаа

2022 оны 07 сарын 15